

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШИЙДВЭР

20 ~~25~~ оны ~~03~~ сарын ~~31~~ -ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

*Компанийн жилийн үйл ажиллагааны болон  
аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаар  
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн холбогдох заалт, тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн тооллогын комиссын 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Сэндли ББСБ” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай

ХУРЛЫН ДАРГА В.НАРАНБАТ



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШИЙДВЭР

2025 оны 03 сарын 31-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

### *Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны төсөв батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дэх заалт, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн холбогдох заалт, Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн тооллогын комиссын 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Б.НАРАНБАТ



Сэндли ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын 2025 оны 3 дугаар сарын 31-ний  
өдрийн 02 тоот шийдвэрийн Хавсралт 1



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ТӨСӨВ**

Утга		Нэг сар	Гишүүдийн тоо	Нэг жил
Тогтмол цалин	Үндсэн	1,500,000	9	162,000,000
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	200,000	1	2,400,000
	Хорооны даргын нэмэгдэл	200,000	3	7,200,000
	Нарийн бичгийн даргын цалин	1,000,000	1	12,000,000
Оролцоонд үндэслэсэн цалин	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон	250,000 /улиралд нэг удаа/	9	9,000,000
Бусад зардал	Хурал зохион байгуулахтай холбоотой зардал			5,000,000
			<b>НИЙТ</b>	<b>197,600,000</b>

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШИЙДВЭР

2025 оны 03 сарын 31-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

### *Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн холбогдох заалт, тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн тооллогын комиссын 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан дор дурдсан нэр дэвшигчдийг “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгосугай:

1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

- 1.1.1. Мөнхтөр овогтой Цолмон;
- 1.1.2. Баттулга овогтой Наранбат;
- 1.1.3. Лхагважав овогтой Нарантуяа;
- 1.1.4. Найдан овогтой Билгүүн;
- 1.1.5. Нармандах овогтой Цэвэгмид;
- 1.1.6. Батбаяр овогтой Эрдэнэ.

1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- 1.2.1. Цэндсүрэн овогтой Саруултуяа;
- 1.2.2. Батмөнх овогтой Цэлмэг;
- 1.2.3. Чойжилсүрэн овогтой Заяа.

2. Хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний талаарх олон нийтэд мэдээлж, сонгогдсон гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д хүргэхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл) болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /БМөнхцэцэг/- т үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Б.НАРАНБАТ

